



МОНГОЛ УЛС
ЁС ЗҮЙН ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах,
шалган шийдвэрлэх талаар авах
арга хэмжээний тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.11 дэх заалт, Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 1.1.2 дахь заалт, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм”-ийн 2.1.2.2, 2.1.2.7 дахь заалт, 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн албан тушаал эрхэлдэг албан хаагчийн гаргах “Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг”-ийн загварыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан загварын дагуу “Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг” гаргуулж хэвших, тэдгээрт ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, олон нийтэд мэдээлж, дүнг жил бүрийн тайланд тусган, харьяалах дээд шатны байгууллагуудаар нэгтгэн Ёс зүйн хороонд дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг төрийн бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтан нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган “Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг” гаргасан албан хаагчийн тоо, зөрчлийн мэдээлэл, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн дүнг жил бүрийн 1 дүгээр сард багтаан Ёс зүйн хорооны хуралдаанд тайлагнаж ажиллахыг Ёс зүйн хорооны Ажлын алба (Н.Ганбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ц.АМАРТӨГС

152501014

Ёс зүйн хорооны 005 оны 09 дугаар
сарын 06-ны өдрийн 07 тогтоолын
хавсралт

ЁС ЗҮЙН НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГ

ATA11169 8448906
9023111371

Дугаар

... он сар өдөр

/Байгууллагын нэр/

/Салбар, нэгжийн нэр/

/Албан тушаал/

/Албан тушаалын ангилал, зэрэглэл/

..... /эцэг, эх-ийн нэр/..... би тухайн
албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахдаа Төрийн албан хаагчийн ёс
зүйн тухай хууль тогтоомжид заасан нийтлэг хэм хэмжээг мөрдөж ажиллана.

Одоо эрхэлж байгаа албан тушаал нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд
өртөх эрсдэлийн үнэлгээгээр I (маш өндөр), II (өндөр) түвшинд гэж үнэлэгдсэн¹
болно.

Хууль тогтоомжоор тогтоосон хэм хэмжээг зөрчвөл хуулийн хариуцлага
хүлээнэ.

МЭДҮҮЛЭГ ГАРГАСАН:

Албан хаагч

/Албан тушаал/

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

ХҮЛЭЭН АВСАН:

Томилох эрх бүхий албан тушаалтан

/Албан тушаал/

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

..... оны сарын өдөр

¹ "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-аар тооцсон эрсдэлийн түвшин болно.